

## 35 АБРАХАМ ИСААК, ИАКОВТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

### 35.1 Хараал идсэн газар ерөөлийн үг ирсэн

Абрамд өгсөн амлалтууд

<sup>1</sup>ЭЗЭН Абрамд айлдсан нь -Чи төрсөн нутгаа,Төрөл садангаа, Эцгийнхээ гэрийг орхиж, Миний чамд зааж өгөх газар уруу яв.<sup>2</sup>Би чамайг агуу үндэстэн болгож, Чамайг ерөөн, Алдар нэрийг чинь агуу болгоно. Тэгээд чи ерөөлийн үндэс болно.<sup>3</sup>Чамайг ерөөгчдийг Би ерөөж, Чамайг хараагч нэгнийг Би хараана.Газар дэлхий дээрх бүх үндэстэн чамаар дамжуулан ерөөгдөнө гэв. <sup>4</sup>Тэгээд Абрам ЭЗЭНий хэлсэн ёсоор явжээ. Лот ч бас хамт явав. Абрам Харанаас гарч явахдаа далан таван настай байжээ. ( Эхлэл 12:1-4 АБ 2004 )

<sup>14</sup>Лотыг Абрамаас салж явсны дараа ЭЗЭН Абрамд -Чи хараагаа өргөн, одоо байгаа газраасаа хойд, урд, баруун, зүүн зүг уруу харагтун. <sup>15</sup>Чамд харагдаж байгаа тэр бүх газар нутгийг Би чамд болон чиний үр хүүхдүүдэд үүрд өгнө. <sup>16</sup>Би бас чиний үр хүүхдүүдийг газар шороо мэт болгоно. Хэрэв хүн газар шороог тоолж чаддаг бол, чиний үр хүүхдүүдийг ч тоолж чадмуй. <sup>17</sup>Босоод, энэ газар нутгаар хөндлөн гулд явж үз. Учир нь Би түүнийг чамд өгнө” гэв. <sup>18</sup>Тэгээд Абрам майхнаа нүүлгэж, Хебронд байгаа Мамрегийн царс модны дэргэд очиж суугаад, тэнд ЭЗЭНд зориулж тахилын ширээ босгожээ. ( Эхлэл 13:14-18 АБ 2004 )

<sup>1</sup>Абрамыг ерэн есөн настай байхад ЭЗЭН Абрамд үзэгдэж -Би бол Төгс Хүчит Бурхан.

Чи Миний өмнө явж, гэм зэмгүй байгтун.

<sup>2</sup>Би чи, бид хоёрын хооронд гэрээ байгуулж,

Чамайг маш их өнөр өтгөн болгоно гэв. ( Эхлэл 17:1-2 АБ 2004 )

<sup>14</sup>ЭЗЭНд дэндүү хэцүү юм байдаг гэж үү? Би тогтоогдсон цагт чамд эргэж ирнэ. Дараа жилийн энэ үед Сара хүүтэй болсон байна гэв. ( Эхлэл 18:14 АБ 2004 )

<sup>27</sup>“Үзэгтүн, Би бол ЭЗЭН, бүх махан биеийн Бурхан. Надад ямар нэгэн зүйл дэндүү хэцүү юу?” ( Иеримиа 32:27 АБ 2004 )

<sup>26</sup>Есүс тэднийг хараад,  
-Энэ нь хүмүүст боломжгүй, харин Бурханд бүх юм боломжтой гэж айлдав. ( Матай 19:26 АБ 2004 )

[ ] Өөрсдийг нь цохьдог түүн рүү хэрхэн эргэн ирж чадахыг та мэдэх үү?

[ ] Бурханд бүх зүйл боломжтой гэдэгт та итгэдэг үү?

### **35.2 Ивээлийн нөхцөл**

#### **А. Хуулийг бүрэн дагаж мөрдвэл**

<sup>1</sup>Тиймээс чи өөрийн Бурхан ЭЗЭНийг хайрлан, Түүний захиа даалгавар, хууль тогтоол, зарлиг, тушаалыг үргэлж дагаж яв. <sup>2</sup>Та нарын Бурхан ЭЗЭНий сахилгажуулалтыг мэдээгүй, хараагүй хөвгүүдтэй чинь би яриагүй гэдгийг өнөөдөр ойлго. Тэд Түүний сүр жавхлан, Түүний хүчирхэг гар, Түүний сунгасан мутрыг, <sup>3</sup>Египетийн төвд Египетийн хаан Фараон болон бүх газар нутагт нь Түүний үйлдсэн тэмдэг, үйлсийг нь, <sup>4</sup>та нарын хойноос хөөн ирсэн тэднийг Улаан тэнгисийн усанд живүүлэх үедээ Египетийн цэргүүд, тэдний агт морьд, тэрэгнүүдэд ЭЗЭНий юу хийснийг болон ЭЗЭН тэднийг бүрмөсөн устгасныг, <sup>5</sup>та нарыг энд ирэх хүртэл цөлд та нарт Түүний юу хийснийг, <sup>6</sup>Реубений хүү, Елиабын хөвгүүд болох Датан, Абирам нарыг хэрхсэнийг, тэр үед газар амаа ангайлган бүх Израилийн дундаас тэднийг, тэдний гэр бүл, тэдний майхан, тэднийг дагасан амьтай бүхнийг залгисныг хараагүй. <sup>7</sup>Харин та нар ЭЗЭНий үйлдсэн энэ бүх агуу үйлсийг нүдээрээ үзсэн билээ.

<sup>8</sup>Тиймээс та нар миний өнөөдөр та нарт өгч буй тушаал бүрийг даган мөрд. Ингэснээр та нар хүчирхэг болж, Иорданыг гатлан, эзэмших гэсэн тэр газраа орж, түүнийг эзэмших юм. <sup>9</sup>Ингэснээр тэдэнд болон тэдний үр хүүхдэд өгөхөөр өвөг дээдэст чинь ЭЗЭНий тангарагласан сүү, балаар бялхсан тэр газарт та нар урт наслах юм.

<sup>10</sup>Чиний эзэмшихээр очих гэж байгаа тэр газар бол чиний гарч ирсэн Египетийн газар нутагтай адилгүй. Египетэд та нар үр суулгаад, ногооны талбай мэт хөлөөрөө усалдаг байсан. <sup>11</sup>Харин чиний эзэмшихээр Иорданыг гатлах гэж байгаа тэр газар бол тэнгэрийн хур бороогоор ундаалдаг хөндий, толгодын орон бөгөөд <sup>12</sup>чиний Бурхан ЭЗЭНий асран хамгаалдаг орон юм. Чиний Бурхан ЭЗЭНий мэлмий жилийн эхнээс аваад эцэс хүртэл үргэлж түүнийг тольдон байдаг билээ. <sup>13</sup>Хэрэв та нар өнөөдөр миний та нарт тушааж байгаа тушаалыг сайтар сонсож, ЭЗЭН Бурханаа хайрлаж, Түүнд бүх зүрх, бүх сэтгэлээрээ зарагдвал <sup>14</sup>ЭЗЭН та нарын газар дээр хур бороог цаг улиралд нь оруулж, хавар намрын бороог илгээж, та нар үр тариа, шинэ дарс, тос авах болно. <sup>15</sup>Тэрээр мал сүргийн чинь төлөө өвс ногоог хээр талд ургуулан, та нар идэж, өег цатгалан байх болно. <sup>16</sup>Та нар болгоомжтой бай! Та нарын зүрх мэхлэгдэн эргэж, өөр бурхдад зарагдан тэдэнд мөргөх вий. <sup>17</sup>Тэгвэл ЭЗЭНий уур хилэн та нарын эсрэг дүрэлзэн тэнгэрийг хаагаад бороо орохгүй, газраас үр тариа ч ургахгүй болно. Та нар ЭЗЭНий өгч буй сайн газраас даруй устана.

<sup>18</sup>Тиймээс та нар миний энэ үгсийг зүрхэндээ, сэтгэлдээ тогтоож, түүнийг тэмдэг болгон бугуйндаа уяж, хоёр нүдний хоорондох сахиус мэт байлга. <sup>19</sup>Та нар түүнийг хөвгүүддээ зааж, гэртээ сууж байхдаа ч, замд явж байхдаа ч, хэвтэхдээ ч, босохдоо ч түүний тухай ярьж бай.

<sup>20</sup>Та нар үүнийг хаалганыхаа хатавч, дааман хаалган дээр бич. <sup>21</sup>Тэгвэл та нарын өвөг дээдэст өгөхөөр ЭЗЭНий тангарагласан газар дээр та нарын болон хөвгүүдийн чинь амьдрал газрын дээр тэнгэрийн орших хоногууд мэт уртасна. <sup>22</sup>Та нар хэрэв миний та нарт тушааж буй энэ бүх тушаалыг сахин, үйлдэж, ЭЗЭН Бурханаа хайрлаж, Түүний бүх замаар явж, Түүнээс зууран байвал <sup>23</sup>ЭЗЭН эдгээр бүх үндэстнийг та нарын өмнөөс хөөн гаргаж, та нар өөрсдөөсөө илүү хүчтэй, илүү том улсуудыг эзэмших болно. ( Дэд хууль 11:1-23 АБ 2004 )

[ ] Египетээс гарсан үеийн сургамжийг хүүхдүүд яагаад санах ёстойг та мэдэх үү?

[ ] Бурхнаас ирдэг ивээл ерөөлийг Бурхны хүүхдүүд яагаад авах ёстойг та мэдэх үү?

[ ] Бурханы хүүхдүүдийн төлөөх ялалт нь өөрсдийн хүч чадлаас бус Түүний үгэнд дуулгавартай байх хамааралтай болохыг та мэдэх үү?

### 35.3 Эзэнээс эмээх

Их Эзэнийг хайрлах гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Бид үүнийг хэрхэн хийх ёстой вэ?

<sup>13</sup>ЭЗЭНээс эмээхүй бол хорон мууг үзэн ядах явдал юм. Бардамнал, ихэмсэг зан, хорон муу зам ба гажсан амыг би жигшдэг. ( Сургаал үгс 8:13 АБ 2004 )

<sup>10</sup>Өөрийн бурханлаг хүмүүсийн сэтгэлийг хамгаалдаг ЭЗЭНийг хайрлагч та нар, бузар мууг үзэн яд. Тэр тэднийг хорон муу хүний гараас авардаг. ( Дуулал 97:10 АБ 2004 )

<sup>24</sup>Та нарын хөлийн ул гишгэх газар бүхэн чинь та нарынх болно. Танай хил хязгаар нь цөлөөс Ливан хүртэл, Евфрат мөрнөөс баруун тэнгис хүртэл үргэлжлэх болно. <sup>25</sup>ЭЗЭН Бурхан чинь та нарт айлдсан ёсоороо та нарын хөл хүрсэн бүх л газрын хүмүүсийг та нараас айх айдас хүйдсээр хучна. Тиймээс та нарын эсрэг хэн ч босож чадахгүй. ( Дэд хууль 11:24:25 АБ 2004 )

### 35.4 Эзэнийг хайрлах гэдэг нь

1. бузар мууг үзэн ядах
2. Түүнээс эмээх
3. Түүний хэлснийг мэдэхдээ баярлах
4. Түүний хэлсэн зүйлийг хийхдээ хянуур хандах
5. Түүний хийсэн зүйлд талархах

6. Тэр амласнаа биелүүлнэ гэдэгт итгэх
7. хамгийн сайнаараа Түүнийг шүтэн бишрэх
8. гэмших зүрхтэй байх
9. магтаалыг хүлээн зөвшөөрөх
10. баяр хөөртэй дуу дуулж, бүжиглэх
11. Түүний хийсэн зүйлд баярлах
12. Түүний хэлсэн үгэнд итгэх
13. Есүс Өөрийн шавь нарыг хайрласан шиг бие биенээ хайрлах

Энэ бол Христ дотор амлагдсан, ялалт байгуулсан амьдрал бөгөөд Бурхан болон хүмүүсийн "гааллыг" олж, амьдралын бэрхшээлийг боломж болгон харж, Үгээр дамжуулан тэнгэрт шагналаа бүрдүүлж итгэлээ сахих (Үгийг сонссоноос ирдэг) Үгийн гэрчлэлтэй амьдрал юм.

### **35.5 Наманчан, эргэж ирэх**

<sup>1</sup>Чиний өмнө миний тавьсан ерөөл хараал буюу энэ бүхэн чамд тохиолдон, ЭЗЭН Бурхандаа хөөгдөж, очсон бүх улсынхаа дотор чи энэ бүхнийг зүрхэндээ санаваас, <sup>2</sup>чи болон чиний хөвгүүд өөрсдийн Бурхан ЭЗЭН уруугаа эргэж, өнөөдөр миний та нарт тушаасан бүгдийн дагуу Түүний үгийг бүх зүрх, бүх сэтгэлээрээ дагаваас <sup>3</sup>ЭЗЭН Бурхан чинь чамайг өрөвдөн, чамайг тараан цацсан бүх улс үндэстнүүдийн дундаас дахин цуглуулж, олзлогдогсдыг чинь буцаана.

<sup>4</sup>Цөлөгдөгсөд чинь тэнгэрийн хязгаарт байсан ч ЭЗЭН Бурхан чинь чамайг тэндээс цуглуулж, чамайг тэндээс эргүүлэн авчирна. <sup>5</sup>Тэгээд ЭЗЭН Бурхан чинь чамайг өвөг дээдсийн чинь эзэмшиж байсан тэр газарт авчирж, чамд түүнийг дахин эзэмшүүлнэ.

Тэрээр чамайг жаргааж, өвөг дээдсээс чинь илүү өнөр өтгөн болгоно. <sup>6</sup>ЭЗЭН Бурхан чинь чамайг өөрийн Бурхан

ЭЗЭНийг бүх зүрх, бүх сэтгэлээрээ хайрладаг болгохын тулд чиний зүрхэнд, чиний үр хүүхдүүдийн зүрхэнд хөвч хөндөх ёслол хийнэ.<sup>7</sup>ЭЗЭН Бурхан чинь чиний дайснууд болон чамайг үзэн ядаж хавчдаг бүхэн дээр энэ бүх хараалыг буулгана.<sup>8</sup>Чи дахин ЭЗЭНий үгийг дуулгавартай дагаж, миний өнөөдөр чамд тушааж буй Түүний бүх тушаалыг биелүүлэх болно.<sup>9</sup>Тэгвэл ЭЗЭН Бурхан чинь чиний гараараа хийдэг аливаа ажил үйлсийг тэтгэн, чиний үр хүүхэд, чиний мал сүргийг өсгөн үржүүлж, газрын чинь ургацыг арвижуулан сайн сайхан болгоно. ЭЗЭН чиний өвөг дээдэст баярласан шигээ чамд дахин баярлаж, чамд сайн сайхныг хайрлана.<sup>10</sup>Учир нь та нар ЭЗЭН Бурханыхаа үгийг дуулгавартай даган, энэ хуулийн номд бичигдсэн Түүний тушаал зарлигийг сахин мөрдөж, бүх зүрх, бүх сэтгэлээрээ өөрсдийн Бурхан ЭЗЭНдээ эргэх юм. ( Дэд хууль 30:1-10 АБ 2004 )

<sup>22</sup>Дэлхийн бүх хязгаар аа, Над уруу эргэж аврагдагтун. Учир нь Би бол Бурхан, Надаас өөр Бурхан байхгүй. <sup>23</sup>Би Өөрөөрөө тангарагласан. Миний амнаас үнэн зөв дотор үг гардаг бөгөөд эргэж буцахгүй. Тиймээс Надад өвдөг бүхэн сөхөрч, хэл бүр тангараглана. <sup>24</sup>Миний тухай тэд “Үнэн зөв, хүч нь зөвхөн ЭЗЭНд бий” гэж хэлнэ”. Хүмүүс Түүн уруу ирж, Түүнд уурсагч бүхэн доромжлогдоно. <sup>25</sup>ЭЗЭНий дотор Израилийн бүх үрс зөвтгөгдөж, алдаршина. ( Исаиа 45:22:25 АБ 2004 )

[ ] Бурхан хүүхдүүдэдээ өөрчлөгдөөгүй ёс зүйгээр ханддагийг та мэдэх үү?

[ ] Эзэн дотор баярлах нь яагаад сэтгэл ханамжийг авчирдаг болохыг та мэдэх үү?

### 35.6 Нигүүлслийг дуудах залбирал

<sup>1</sup>Аяа, Та тэнгэрийг яран, доош бууж ирвэл, Таны оршихуйд уулс доргин чичрэхсэн. <sup>2</sup>Ширэнгэ бутыг шатаадаг гал мэт, ус буцалгадаг гал адил Өөрийнхөө оршихуйд үндэстнүүдийг чичрүүлэхийн тулд Өөрийн нэрийг дайснууддаа мэдүүлэхээр бууж ирээч. <sup>3</sup>Учир нь бидний хүсээгүй аймшигт үйлсийг Та хийх үед, Таныг доош буухад уулс Таны оршихуйд чичрэв.

<sup>4</sup>Өөрийг нь итгэн хүлээгч нэгний төлөө үйлддэг Танаас өөр Бурханыг эртнээс нааш тэд сонсоогүй, чихээрээ сонсоогүй бөгөөд нэг ч нүд хараагүй. <sup>5</sup>Үнэн зөвийг баяртайгаар үйлдэгч, Таны замуудад Таныг санадаг хүнтэй Та уулздаг.

Үзэгтүн, бид нүгэл үйлдэж, үүнийгээ удаан хугацаагаар үргэлжлүүлсээр байсан учир Та уурласан. Бид аврагдах болов уу? <sup>6</sup>Бид бүгдээрээ бузар нэгэн мэт болсон бөгөөд бидний бүх зөв үйлс нь бохир хувцас мэт байдаг. Бид бүгдээрээ навч мэт хатаж, бидний нүгэл нь биднийг салхи мэт хийсгэнэ. <sup>7</sup>Таны нэрийг дуудан Танаас зуурахаар өндийх хүн нэг ч алга. Учир нь Та биднээс нүүрээ нууж, биднийг өөрсдийн минь нүглийн хүчинд тушаасан.

<sup>8</sup>Гэвч эдүгээ ЭЗЭН, Та бол бидний Эцэг билээ.

Бид шавар, Та бол бидний ваарчин.

Бид бүгдээрээ Таны мутрын бүтээл.

<sup>9</sup>ЭЗЭН минь. Хэмжээ хязгааргүй бүү хилэгнээч.

Нүглийг үүрд бүү дурсаач.

Үзэгтүн, одоо хар, бид бүгд Таны ард түмэн.

<sup>10</sup>Таны ариун хотууд, Сион ч хүртэл зэлүүд газар боллоо.

Иерусалим эзгүйрлээ.

<sup>11</sup>Эцэг өвгөдийн маань Таныг магтаж байсан газар болох бидний ариун үзэсгэлэнт өргөө галд шатжээ.

Бидний бүх үнэт юмс нуранги боллоо.

<sup>12</sup>ЭЗЭН минь. Эдгээрийг Та тэвчсээр байх уу?

Та дуугүй байсаар, хэмжээ хязгааргүйгээр биднийг зовоох уу? (Исаиа 64:1:12 АБ 2004 )

<sup>1</sup>Яагаад үндэстнүүд уурандаа шатаж,

Ард түмнүүд дэмий хуйвалдана вэ?

<sup>2</sup>Газар дэлхийн хаад бат зогсож,

Удирдагчид хоорондоо зөвлөлдөж,

ЭЗЭН ба Түүний Гослогдсон Нэгэнийг эсэргүүцэн,

<sup>3</sup>“Бид тэдний гинжийг тасалж,

Хүлгийг нь өөрсдөөсөө зайлуулцгаая!” гэж тэд хэлэв.

<sup>4</sup>Тэнгэрт залрагч инээж,

Тэднийг Эзэн тохуурхаж байна.

<sup>5</sup>Тэгээд Тэр тэдэнд Өөрийн уураар айлдаж,

Өөрийн хилэнгээр тэднийг айлган,

<sup>6</sup>“Миний ариун уул Сионд

Би Өөрийн хааныг өргөмжилсөн” гэнэ.

<sup>7</sup>“Би ЭЗЭНий зарлигийг тунхаглана.

Тэр надад хэлэхдээ

“Чи бол Миний Хүү,

Өнөөдөр Би Чамайг төрүүлсэн.

<sup>8</sup>Надаас гуй! Би үндэстнүүдийг Чиний өв болгон,

Дэлхийн хязгааруудыг ч Чиний эзэмшил болгон өгнө.

<sup>9</sup>Чи тэднийг төмөр таягаар хэмх цохиж,

Шавар сав шиг бутлах болно” гэсэн”. ( Дуулал 2:1-9 АБ 2004 )

<sup>1</sup>Бурхан босож, дайснууд нь таран бутарч,

Түүнийг үзэн ядагчид Түүний өмнөөс зугтаг.

<sup>2</sup>Утаа замхардгийн адил тэднийг хөөгөөч.

Лааны тос галын өмнө хайлдгийн адил

Хорон муу хүнийг Бурханы өмнө сөнөөгөөч.

<sup>3</sup>Харин зөв шударга хүмүүсийг баярлуул. Тэднийг Бурханы өмнө баяр хөөр болго.

Тэднийг баясалтайгаар баярлуул. ( Дуулал 68:1-3 АБ 2004 )

<sup>7</sup>Би ЭЗЭНий энэрэл хайрыг дурьдан, ЭЗЭНий бидэнд соёрхсон бүхэн хийгээд Израилийн гэрт үзүүлсэн агуу их ивээлийнх нь дагуу Түүний магтаалыг сануулав. Эдгээрийг Тэр Өөрийн өршөөлийн дагуу Өөрийн үлэмж их энэрэл хайрын ёсоор тэдэнд соёрхсон билээ.

<sup>8</sup>“Үнэхээр тэд бол Миний ард түмэн бөгөөд худал хуурмагаар хандахгүй хөвгүүд юм” гэж Тэр айлдав. Тэгээд Тэр тэдний Аврагч болов. <sup>9</sup>Тэдний бүх л зовлонд оролцон Тэр зовсон бөгөөд Түүний оршихуйн тэнгэр элч тэднийг аварсан. Өөрийн хайр, өршөөл дотор Тэр тэднийг аварсан. Тэрээр эртний бүхий л өдрүүдэд тэднийг өргөн, явсан билээ.

<sup>10</sup>Харин тэд эсэргүүцэн, Түүний Ариун Сүнсийг гомдоов. Тийм учраас Тэр эргэн, тэдний дайсан болж, тэдний эсрэг Өөрөө дайтсан юм. <sup>11</sup>Дараа нь Түүний ард түмэн Мосегийн үеийн эртний өдрүүдийг дурсан санасан. Өөрийн сүргийн хоньчидтой нь хамт тэднийг тэнгисээс гаргасан Тэр хаана байна вэ?

Тэдний дунд Өөрийн Ариун Сүнсийг оруулсан Тэр хаана байна вэ? <sup>12</sup>Хэн Мосегийн баруун гарт байхаар Өөрийн цог жавхлант мутрыг явуулсан бэ? Өөртөө мөнх нэрийг бий болгохын тулд тэдний өмнө усыг хувааж, <sup>13</sup>тэднийг гүн усан дундуур хэн удирдав? Тал нутгийн морь шиг тэд бүдрээгүй.

<sup>14</sup>Үхэр сүрэг хөндий уруу буух шиг ЭЗЭНий Сүнс тэдэнд амгаланг өгөв. Та Өөртөө цог жавхлант нэрийг бий болгохоор Өөрийн ард түмнийг ийнхүү удирдсан билээ. ( Дуулал 63:1-14 АБ 2004 )

<sup>15</sup>Та тэнгэрээс доош харж,  
Өөрийн ариун, цог жавхлант газраас үзээч.  
Таны зүтгэл, Таны хүчит үйлс хаана байна вэ?  
Таны энхрийлэл болон өрөвч сэтгэл надаас холджээ.

<sup>16</sup>Хэдийгээр Абрахам биднийг мэдэхгүй,  
Израиль биднийг танихгүй боловч Та бидний Эцэг билээ.  
Өө, ЭЗЭН, Та бидний Эцэг.

Эртнээс Таны нэр бол бидний Аврагч.

<sup>17</sup>Өө, ЭЗЭН,  
Та яагаад биднийг Өөрийнхөө замаас төөрүүлэн,  
бидний зүрхийг хатууруулан,  
Танаас эмээхгүй болгосон юм бэ?  
Таны өв залгамжлалын овгууд болох Таны боолуудын төлөө эргээч.

<sup>18</sup>Ариун ард түмэн чинь Таны ариун газрыг богино хугацаанд эзэмшсэн.

Бидний дайснууд нураан гишгэсэн.

<sup>19</sup>Танд хэзээ ч захирагдаж байгаагүй,  
Таны нэрээр нэрлэгдэж байгаагүй хүмүүстэй бид адилхан боллоо. ( Исаиа 63:15-19 АБ 2004 )

[ ] Дайсан нь хэн болохыг та мэдэх үү?

[ ] Таныг сүйрүүлэх хүчийг дайсан тань хэрхэн олж авсныг та мэдэх үү?

[ ] Та дайсныхаа эсрэг хэрхэн ялахаа мэддэг үү?

[ ] Даниел улс ооныхоо төлөө хэрхэн залбирсныг та мэдэх үү?

### 35.7 Өөрийн нэрийг агуу болгох

Абрамд өгсөн амлалтууд

<sup>1</sup>ЭЗЭН Абрамд айлдсан нь  
-Чи төрсөн нутгаа,  
Төрөл садангаа,  
Эцгийнхээ гэрийг орхиж,

Миний чамд зааж өгөх газар уруу яв.  
<sup>2</sup>Би чамайг агуу үндэстэн болгож,  
 Чамайг ерөөн,  
 Алдар нэрийг чинь агуу болгоно.  
 Тэгээд чи ерөөлийн үндэс болно.  
<sup>3</sup>Чамайг ерөөгчдийг Би ерөөж,  
 Чамайг хараагч нэгнийг Би хараана.  
 Газар дэлхий дээрх бүх үндэстэн чамаар дамжуулан  
 ерөөгдөнө гэв. ( Эхлэл 12:1-3 АБ 2004 )

[ ] Түүний дуудлагыг дуулгавартай дагадаг нэгэнүүдэд тэнгэрлэг адислал, нигүүсэл ирдэг. Та дуулгавартай байдаг уу?

[ ] Дуулгавартай байхад Тэр амласан зүйлээ хийдэг гэдэгт та итгэдэг үү?

### 35.8 Сонгогдогсдын давуу тал

<sup>1</sup>Иймээс иудей хүний давуу тал, эсвэл хөвч хөндөлтийн ашиг нь юу вэ?

<sup>2</sup>Аль ч талаараа үлэмж их юм. Бүхнээс өмнө, Бурханы үгс тэдэнд даатгагдсан билээ. <sup>3</sup>Зарим нь итгээгүй бол яах вэ? Тэдний итгэлгүй байдал Бурханы итгэмжит байдлыг хүчингүй болгоно гэж үү? <sup>4</sup>Бүү ийм байх болтугай!

Хүн бүр худалч байсан ч Бурхан үнэн байг. Энэ тухай “Та айлдахдаа зөвтгөгдөж Та шүүгдэхдээ ялна”

<sup>5</sup>Хэрэв бидний зөв бус нь Бурханы зөвийг харуулдаг юм бол, бид юу хэлэх билээ? Уур хилэн буулгагч Бурхан нь зөв биш гэж үү? Би хүний ёсоор ярьж байна. <sup>6</sup>Бүү ийм байх болтугай! Тийм бол Бурхан ертөнцийг яаж шүүх юм бэ? <sup>7</sup>Хэрэв миний худал үгээр Бурханы үнэн нь Өөрийнх нь алдар дотор бялхдаг юм бол яагаад би одоо ч гэсэн нүгэлтэн адил шүүгддэг билээ? <sup>8</sup>“Сайныг гаргахын тулд мууг үйлдэцгээ” гэж ярьж болохгүй гэж үү? Зарим нь биднийг ингэж ярьдаг хэмээн гүтгэн хэлдэг. Тэдний шийтгэл нь шударга юм. ( Ром 3:1-8 АБ 2004 )